

БАТЛАВ  
ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

ЗАМ ТЭЭВРИЙН САЛБАРТ МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН  
ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

БАТЛАВ  
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА

Н.ЦАГААНХҮҮ

2017 оны 03 дугаар  
сарын 10-ны өдөр

№ 34

Улаанбаатар хот

Нэг талаас Зам, тээврийн хөгжлийн яамыг төлөөлж Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Т.Гомбосүрэн, нөгөө талаас Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг төлөөлж Дэд бүтцийн хяналтын газрын дарга Д.Жаргал нар дараах нөхцөлөөр тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Зам, тээврийн салбарт мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх, хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.

1.2. Хоёр тал зам, тээврийн салбарт Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллагаас батлан гаргасан дүрэм журам, стандартын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллана.

1.3. Хяналт шалгалтын ажилд “Төрийн хяналт шалгалтын тухай” хууль, түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллагаас батлан гаргасан дүрэм, журам, Мэргэжлийн хяналт шалгалтын стандарт, зөвлөмж, заавар, “Автотээврийн тухай” хуулийн 21,22 дугаар зүйл, “Төмөр замын тухай” хуулийн 13 дугаар зүйл, “Авто замын тухай” хуулийн 8,9 дүгээр зүйл, “Барилгын тухай” хууль болон бусад хуулийн холбогдох заалтуудыг үйл ажиллагаандаа удирдлага болгон эрх зүйн хэм хэмжээг мөрдөж ажиллана.

1.4. Хяналт шалгалтын үйл ажиллагаанд “Төрийн хяналт шалгалтын тухай” хуулийн 4 дүгээр зүйлд заасан зарчмыг баримтлан хяналт шалгалтыг зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу хийхээс гадна тухайн онд хийх хамтарсан хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг баталж, шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөт бус шалгалтыг хоёр тал зөвшилцөн хамтран хэрэгжүүлнэ.

1.5. Зам, тээврийн хөгжлийн яамны харьяа орон нутагт ажиллаж байгаа улсын байцаагчдын хяналт шалгалтын ажлыг тухайн аймаг, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Хилийн мэргэжлийн хяналтын хэлтсийн хяналтын үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулах, улсын байцаагчдын хяналт шалгалтын ажлын хагас, бүтэн жилийн тайланд үнэлэлт, дүгнэлт өгч, хамтран ажиллана.


1.6. Улсын байцаагчдыг сургалтад хамруулах, давтан сургах ажлыг хоёр тал хамтран зохион байгуулна.

1.7. Энэхүү гэрээ нь 2 жилийн хугацаатай хийгдэх бөгөөд хоёр тал тохиролцон гарын үсэг зурснаар хүчинтэйд тооцогдоно.

### Хоёр. Зам, тээврийн хөгжлийн яамны эрх, үүрэг

2.1. Зам, тээврийн салбарт мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллах ажилтнуудад улсын байцаагчийн эрх олгуулах, сунгуулах, цуцлахтай холбоотой асуудлыг тус яам Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт тавьж шийдвэрлүүлнэ.

2.2. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2009 оны 214 дүгээр тушаалаар баталсан “Хуулиар эрх олгогдсон байгууллагад улсын байцаагч ажиллуулах журам”-ын



1.6-д заасныг үндэслэн тус байгууллагын нэртэй улсын байцаагчийн акт, албан шаардлага, дүгнэлтийн хэвлэмэл хуудсыг хэвлүүлж, байцаагч нарт олгоно.

2.3. Улсын байцаагчдын үнэмлэх, тэмдэг, торгууль шийтгэврийн хэрэглээнд хяналт тавьж ажиллана.

2.4. Торгууль, шийтгэврийн хуудсыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын санхүү болон аймгийн Мэргэжлийн хяналтын газрын санхүүгээс авч, зарцуулалтын тайланг МХЕГ-ын даргын 2017 оны А/14 дүгээр тушаалын 1 болон 3 дугаар хавсралтын дагуу улирал бүр гарган, тогтоосон журмын дагуу тооцоо хийнэ.

2.5. Улсын байцаагчдын тавьсан торгууль шийтгэврийн орлогыг тухай бүр Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын "хяналтын орлого"-ын дансанд төвлөрүүлж, тооцоог МХЕГ-ын Санхүү, аж ахуйн хэлтсийн хариуцсан ажилтантай хийж байна.

2.6. Хяналт шалгалтын ажлын хагас, бүтэн жилийн нэгдсэн тайланг тухайн жилийн 6 болон 12 дугаар сарын 10-ны дотор Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Дэд бүтцийн хяналтын газарт хүргүүлнэ.

2.7. Улсын байцаагчдын ажиллах нөхцөл, баталгааг бие дааж хангана.

### **Гурав. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын эрх, үүрэг**

3.1. Зам, тээврийн хөгжлийн яаманд ажиллаж буй хяналтын улсын байцаагчдыг мэргэжил, арга зүйн болон хяналт, шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдуулан батлан гаргасан эрх зүйн акт, мэдээллээр хангана.

3.2. Хяналт шалгалтын хагас, бүтэн жилийн нэгдсэн тайлан, улсын байцаагч нарын тайланг хүлээн авч, үнэлэлт дүгнэлт, зөвлөмж, зааварчилгаа өгөхөөс гадна шаардлагатай тохиолдолд улсын байцаагч нарын ажлын үнэлгээг үндэслэн холбогдох шагнал урамшуулал, хариуцлага тооцох арга хэмжээг авна.

3.3. Зам, тээврийн хөгжлийн яам болон түүний харьяа байгууллагад ажиллах ажилтанд улсын байцаагчийн эрх олгуулахаар хүргүүлсэн тус яамны саналыг үндэслэн Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2009 оны 214 дугаар тушаалаар батлагдсан "Хуулиар эрх олгогдсон байгууллагад улсын байцаагч ажиллуулах журам"-д заасны дагуу улсын байцаагчийн эрх олгох асуудлыг шийдвэрлэнэ.


3.4. Улсын байцаагчтай холбоотой иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирсэн өргөдөл, гомдлыг хянан үзэж, улсын байцаагчийн ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн, мэргэжлийн алдаа гаргасан бол улсын байцаагчийн эрхийг цуцлах хүртэл арга хэмжээ авна.

3.5. Хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотой болон бусад хууль, тогтоомжийг боловсронгуй болгох талаар хамтран санал, дүгнэлт гаргаж, асуудлыг эрх бүхий байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх.

3.6. Шаардлагатай тохиолдолд Мэргэжлийн хяналтын байгууллагаас хийх төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтад зам, тээврийн салбарт ажиллаж буй улсын байцаагчдыг татан оролцуулж болно.

3.7. Торгууль, шийтгэврийн хуудсаар тогтмол хангаж зарцуулалтад хяналт тавьж ажиллана.

3.8. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, аймгуудын мэргэжлийн хяналтын газар, Хилийн мэргэжлийн хяналтын хэлтсээс зохион байгуулах сургалт, семинар, зөвлөгөөн зэрэг холбогдох арга хэмжээнд Зам, тээврийн салбарт ажиллаж байгаа хяналтын улсын байцаагч нарыг оролцуулах.




## Дөрөв. Бусад асуудал


- 4.1. Хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулахад хоёр тал аливаа хэлбэрээр саад учруулахгүй.
- 4.2. Хамтын ажиллагааны явцад хоёр байгууллагын эрх ашиг хөндөгдсөн асуудлыг тухай бүр удирдлагын хэмжээнд хэлэлцэн шийдвэрлэнэ.
- 4.3. Хамтарсан үзлэг, шалгалт, нэгдсэн арга хэмжээний талаар оны эхэнд төлөвлөгөө гарган хамтран баталж ажиллана.
- 4.4. Хамтарсан үзлэг, шалгалт, нэгдсэн арга хэмжээний дүнг гарган хэлэлцэх болон хамтын ажиллагааны бусад асуудлыг ажил хэргийн шугамаар тухай бүр шийдвэрлэнэ.
- 4.5. Гэрээг жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор дүгнэнэ.
- 4.6. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох ба гэрээний нэмэлт, өөрчлөлт нь энэхүү гэрээний нэгэн адил хүчинтэй байна.
- 4.7. Гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлээгүй болон гэрээний нөхцөлийг биелүүлээгүй бол гэрээг нэг тал дангаар цуцална. Ийнхүү цуцлахдаа нөгөө талд бичгээр мэдэгдэнэ.
- 4.8. Гэрээ байгуулагч байгууллага татан буугдсан, гэрээний харилцааг зохицуулсан эрх зүйн орчинд өөрчлөлт орж гэрээг дуусгавар болгох нөхцөл байдал бий болсон, эсвэл талууд харилцан тохиролцсоноор гэрээ дуусгавар болно.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ  
ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,  
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ҮҮРГИЙГ ТУР ЭРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Т.ГОМБОСҮРЭН



МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДЭД БҮТЦИЙН ХЯНАЛТЫН  
ГАЗРЫН ДАРГА



Д.ЖАРГАЛ




БАТЛАВ.  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Ж.БАТ-ЭРДЭНЭ

БАТЛАВ.  
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ  
ДАРГА  
Н.ЦАГААНХҮҮ


ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ, МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
2017 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Бүтээгдэхүүний нэр төрөл	Хугацаа	Хариуцах байгууллагууд
<b>А. Хяналтшалгалт</b>			
<b>1. Автотээвэр</b>			
1.1	Техникийн хяналтын үзлэгийн хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага (Доктор авто сүлжээ ХХК, Нива трейд ХХК, Монгол терминал ХХК)-дын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	III улирал	ЗТХЯ-ны ХШУДАГ, МХЕГ-ын ДБХГ-ын автотээврийн хяналтын улсын /ахлах/ байцаагчид
<b>2. Автозам</b>			
2.1	Улсын төсөв, гадаадын зээл тусламж болон бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтаар шинээр баригдаж буй Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 143 км, Увс аймгийн Наранбулаг сумын нутаг Хяргас нуурын зүүн хаяа-Сонгино сум чиглэлийн 135,5 км, Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км, Баянхонгор-Алтай чиглэлийн 129км, Багануур-Өндөрхаан чиглэлийн 45 км замын засвар шинэчлэлтийн ажилд хяналт, шалгалт хийх, зөвлөмж өгөх	II-IV улирал	ЗТХЯ-ны ХШУДАГ, МХЕГ-ын ДБХГ-ын авто замын хяналтын улсын /ахлах/ байцаагчид АЗТБХЗГ, "ЗТХТ" ТӨҮГ-ын холбогдох мэргэжилтэн
2.2	Булган аймгийн Сэлэнгэ сумын Сэлэнгэ мөрний 422.5 у/мтөмөр бетон гүүр	I-II улирал	ЗТХЯ-ны ХШУДАГ, МХЕГ-ын ДБХГ-ын авто замын хяналтын улсын /ахлах/ байцаагчид, "ЗТХТ" ТӨҮГ-ын холбогдох мэргэжилтэн
2.3	Улсын чанартай авто зам, замын байгууламжийн ашиглалт, хамгаалалт, арчлалт, засварын ажлын гүйцэтгэл, хөдөлгөөний аюулгүй байдал, тэмдэг тэмдэглэгээний стандартын хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, осол аварь гарах нөхцөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах, мэргэжлийн арга зүйн зөвлөмж өгөх	I-III улирал	ЗТХЯ-ны ХШУДАГ-ын, МХЕГ-ын ДБХГ, тухайн орон нутгийн МХГ-ын авто замын хяналтын улсын /ахлах/ байцаагчид
<b>Б. Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох</b>			
1	Автотээврийн салбарын эрх зүйн орчинг сайжруулах талаар холбогдон гарах болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартуудад санал өгөх	II-IV улирал	ЗТХЯ, МХЕГ-ын ДБХГ-ын холбогдох газрын байцаагчид, мэргэжилтэн
2	Зам, тээврийн салбарын эрх зүйн орчинг сайжруулах талаар гарах хууль тогтоомж, норм дүрэм, журам, стандартуудыг боловсруулахад хамтран ажиллах	II-IV улирал	ЗТХЯ, МХЕГ-ын ДБХГ-ын холбогдох газрын байцаагчид, мэргэжилтэн
3	Зам, тээврийн хөгжлийн яамнаас боловсруулах болон нэмэлт, өөрчлөлт оруулах автотээвэр,	II-IV улирал	ЗТХЯ, МХЕГ-ын ДБХГ-ын холбогдох газрын




3	Зам, тээврийн хөгжлийн яамнаас боловсруулах болон нэмэлт, өөрчлөлт оруулах автотээвэр, усан зам, авто зам, нисэх, төмөр замын салбарын дүрэм, журам, хөтөлбөр, төсөлд санал өгөх	II-IV улирал	ЗТХЯ, МХЕГ-ын ДБХГ-ын холбогдох газрын байцаагчид, мэргэжилтэн
В. Байгууллага, иргэдэд зориулсан сургалт семинар, зөвлөн туслах, урьдчилан сэргийлэх ажил, тандалт судалгааг зохион байгуулах			
1	Хот хоорондын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч "Хүслэнт ажнай" ХХК, "Тамирын бугат" ХХК-д "зөвлөн туслах үйлчилгээ"-г үзүүлэх	III улирал	ЗТХЯ-ны ХШУДАГ-ын ЗТХХ, МХЕГ-ын ДБХГ-ын автотээврийн хяналтын улсын /ахлах/ байцаагчид
2	"Анхдагч групп" ХХК-ийн үйл ажиллагаанд тандалт, судалгаа хийх	II улирал	ЗТХЯ-ны ХШУДАГ-ын ЗТХХ, МХЕГ-ын ДБХГ-ын автотээврийн хяналтын улсын /ахлах/ байцаагчид
3	Авто засвар, үйлчилгээ эрхлэгчдэд зориулсан сургалт зохион байгуулж, явуулах	II улирал	ЗТХЯ-ны ХШУДАГ-ын ЗТХХ, аймаг, нийслэлийн МХГ-ын автотээврийн хяналтын улсын /ахлах/ байцаагчид
4.	"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын улсын байцаагч нарт зориулсан "Авто тээврийн хяналтын улсын байцаагч нарын хяналт шалгалт хийх ур чадварыг дээшлүүлье" сэдэвт "сургалт зохион байгуулах	II улирал	ЗТХЯ-ны ХШУДАГ-ын ЗТХХ, аймаг, нийслэлийн МХГ-ын автотээврийн хяналтын улсын /ахлах/ байцаагчид
5	Улсын чанартай зам замын байгууламжийн байнгын бэлэн байдал хариуцдаг байгууллагуудад мэргэжлийн болон хууль эрх зүйн "зөвлөн туслах үйлчилгээ"-г үзүүлэх	I-III улирал	ЗТХЯ-ны ХШУДАГ-ын, МХЕГ-ын ДБХГ, тухайн орон нутгийн МХГ-ын авто замын хяналтын улсын /ахлах/ байцаагчид
6	Зам, тээврийн хяналтын улсын байцаагч нарыг мэргэшил дээшлүүлэх сургалтад хамруулах	I-II улирал	ЗТХЯ, МХЕГ-аас холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД  
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Т.ГОМБОСҮРЭН

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД  
БҮТЦИЙН ХЯНАЛТЫН  
ГАЗРЫН ДАРГА



Д.ЖАРГАЛ

2017 оны 03 дугаар сарын 10...

